МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр Дугаар А/144 Мөрөн сум

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах аймгийн тооллогын комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.4, Засгийн газрын 2020 оны 9, 2022 оны 278 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах аймгийн тооллогын Комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай.

2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлын төлөвлөгөө боловсруулан мөрдүүлэх, байгууллагын комиссыг удирдлагаар хангах, хөрөнгийг газар дээр нь хяналтын тооллого хийх, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа ашиглалтгүй болон илүүдэлтэй үндсэн хөрөнгө, ашиглах хугацаа нь дууссан, цаашид худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах талаар дүгнэлт гаргах, байгууллагуудын үзлэг тооллогын ажлын дүнг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээн авч 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор улсын нэгтгэлд хамруулах ажлыг зохион байгуулахыг тооллогын аймгийн комисс (М.Хуягбаатар)-т даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

d/zahiramj

Хөвсгөл аймгийн Засаг даргын
2022 оны 05 сарын 05 -ны өдрийн А/144-р
захирамжийн хавсралт

2022 ОНЫ ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ЗОХИОН БАЙГУУЛАХ АЙМГИЙН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Тооллогын комиссын дарга: Аймгийн Засаг даргын орлогч М.Хуягбаатар

Тооллогын комиссын орлогч дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар

Нарийн бичгийн дарга: Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсорогдог.

Гишүүд: - Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогч Л.Батжаргал

- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Агентлаг байгууллага, Эрүүл мэндийн байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан Ахлах мэргэжилтэн Н.Шинэбаяр
- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Аж ахуйн нэгж, Нутгийн захиргааны байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн Ц.Бэхбаяр
- Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Боловсрол, Соёлын байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн Ч.Лхагвамядаг
- Аймгийн Эрүүл мэндийн газрын Барилга, эмнэлгийн тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн Г.Баяржаргал
- Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Ерөнхий нягтлан бодогч Г.Баасанням
- Аймгийн Соёл, урлагийн газрын мэргэжилтэн Х.Баасансүрэн
- Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга З.Нямбаяр
- Аймгийн Автотээврийн төвийн дарга Ө.Баттулга
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Мөнгөнзул